




ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН МАН-ЫН
ХОРООНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР
/2020-2024 ОН/

АЛТАЙ ХОТ
2020 ОН



“Сумаа хамтдаа хөгжүүлє” мөрийн хөтөлбөр

Говь-Алтай Эрдэнэ сумын МАН-ын хорооны

2020 оны 24 сарын 24-ны өдрийн

с/у дугаар тогтоолын хавсралт

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН МАН-ЫН ОРОН НУТГИЙН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ, “СУМАА ХАМТДАА ХӨГЖҮҮЛБӨР”
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

/2020-2024/

УРИА: Эгэлгүй сайхан Эрдэнэ нутгаа

Хамтдаа хөгжүүлє.

АГУУЛГА

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ- НИЙГМИЙН ДЭВШИЛ

1. Эрүүл мэндийн бодлого
2. Биеийн тамир, спортын бодлого
3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжлийг дэмжих бодлого
4. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого
5. Хүүхэд залуучууд, ахмад настан, эмэгтэйчүүдийг дэмжих бодлого

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ-АЖЛЫН БАЙР


1. Мал аж ахуйг эрчимжүүлэх
2. Газар тариалан эрхлэлтийг нэмэгдүүлэх
3. Бизнес эрхлэлтийг дэмжих
4. Төсөл, зээлийн таатай орчныг бий болгох
5. Ажлын байрыг нэмэгдүүлэх

ГУРАВ. ДЭД БҮТЭЦ-ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТ

1. Ундны усны найдвартай эх үүсвэрийг санаачлах
2. Эрчим хүчний өргөтгөл, шинэчлэл
3. Зам, тээвэр, үйлдвэржилтийн бүтээн байгуулалт
4. Хот байгуулалт, барилга орон сууцны хөгжил
5. Мэдээлэл, харилцаа холбооны дэвшил

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН-АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

1. Онгон байгалиа хамгаалах
2. Орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлэх
3. Бичил уурхай иргэдийн оролцоо
4. Улс болон орон нутгийн тусгай хамгаалалтыг нэмэгдүүлнэ
5. Цөлжилт, элсний нүүдлээс хамгаалах, ногоон байгууламж



ТАВ. ИРГЭДИЙН ОРОЛЦОО- ЗӨВ ЗАСАГЛАЛ

1. Эрх мэдэлтнийг биш, эрх зүйт төрийг дээдэлнэ
2. Түмэндээ ойртсон төрийн үйлчилгээ
3. Авилга, хүнд суртал, чирэгдэлгүй зөв засаглал
4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах
5. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ-НИЙГМИЙН ДЭВШИЛ

Мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр бүрэн хангагдсан, эрүүл мэнд, Боловсрол, соёл, халамжийн үйлчилгээг чанаржуулж, хүртээмж үр өгөөжийг нэмэгдүүлэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар иргэн бүрийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

1.1. Эрүүл мэндийн бодлого


- 1.1.1. Орон нутгийн эмч, эмнэлгийн ажилтны хүрэлцээ хангамж ур чадварыг сайжруулан, эмчилгээ оношлогооны шинэ дэвшилтэт арга барил эзэмшүүлж, нэвтрүүлэх зэрэг асуудлыг үе шаттай шийдвэрлэнэ.
- 1.1.2 “Эрүүл хүүхэд – Эрдэний ирээдүй” , “ Амны хөндий” дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн сургалт, сурталчилгааг тогтмолжуулна.
- 1.1.3 Эрүүл мэндийн явуулын үзлэг, оношилгоог бүх багт жил бүр зохион байгуулна.
- 1.1.4 Уламжлалт болон физик эмчилгээг түлхүү хөгжүүлж, уг тусламжийг үзүүлэх мэргэжилтэн бэлтгэнэ.
- 1.1.5 Сумын нэгдсэн эмнэлэгтэй нягт уялдан, сүүлийн үеийн техник, тоног төхөөрөмжүүдийг нэвтрүүлэх замаар эмнэлгийн чанар хүртээмжийг сайжруулна.
- 1.1.6 Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл барьж ахмад настан, хүүхдийн сувилалын тасаг байгуулна.

1.2. Биеийн тамир, спортын бодлого

1.2.1. “ Аваргын гараа” хөтөлбөр хэрэгжүүлж , өсвөр үеийн шигшээ багийг спортын гурваас доошгүй төрлөөр бэлтгэж, өсвөр үеийн тамирчдыг дэмжиж ажиллана.

1.2.2. Хөдөөгийн хүүхэд залуучуудыг биеийн тамир, спортоор хичээллэх боломж нөхцөлийг бүрдүүлж, спорт заалыг ашиглалтанд оруулж, сумын биеийн тамирын аргазүйчийн орон тоо гаргаж биеийн тамир спортоор хичээллэх боломжийг бүрдүүлж ажиллана.

1.2.3. Үндэсний спортын төрлүүдийг бүх нийтийн хүртээл болгон хөгжүүлнэ.



1.3.Боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжлийг дэмжих бодлого

1.3.1. Бүх нийтийн боловсролын түвшинг дээшлүүлэн боловсролын байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулан, сургалтын материаллаг бааз, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, орчин үеийн дэвшилтэт сургалтын орчинг сумдаа бий болгоно.

1.3.2. Боловсрол, соёлын салбар дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бүхий л талаар дэмжиж, хувиараа нэмэлт болон гүнзгийрүүлэн судлах сургалтын орчинг бүрдүүлж сургууль, цэцэрлэгийн анги дүүргэлтийн түвшинг нэмэгдүүлнэ.

1.3.3. Урлагийн гоц авъяастан, урчууд, уран бүтээлчдийг тодруулан авъяасыг нь хөгжүүлэх хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлнэ.

1.3.4. Насан туршийн боловсролын хүртээмж, чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ.

1.3.5. Боловсрол, соёлын салбарыг чадварлаг боловсон хүчнээр тасралтгүй хангагдах боломжийг бий болгож, удирдах ажилтны ур чадвар, арга барилыг дээшлүүлнэ.

1.4. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого

1.4.1. ТБ байгууллагууд хөршийн холбоодтой хамтран ажиллаж, хүүхэд залуучуудын хэрэгцээ шаардлагад суурилсан, сурч боловсрох, хөгжих, соёл хүмүүжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

1.4.2. Бизнес хөгжлийн төвийг их засварт оруулж сумын брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, ажлын байр шинээр бий болгож буй аж ахуй нэгж, байгууллагыг бүх түвшинд орон нутгийн бодлогоор дэмжинэ.

1.4.3. Байгаль орчныг хамгаалах бүтээн байгуулалт, нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн тохижилт үйлчилгээний ажилд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийг өргөнөөр татан оролцуулах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.


1.5. Хүүхэд залуучууд, ахмад настан, эмэгтэйчүүдийг дэмжих бодлого

1.5.1. Ахмад настан, эмэгтэйчүүдийн хэрэгцээ чадамжинд суурилсан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөтөлбөр боловсруулан байнгын нөхцөлийг бүрдүүлнэ.

1.5.2. Нийгмийн эрүүл мэнд, боловсрол, соёлын салбарын хөгжилд шинэ өөрчлөлтийг бий болгоно.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ - АЖЛЫН БАЙР

Эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, хөгжилд чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэн үр ашгийг нь нэмэгдүүлж, ажлын байр бий болгон ард иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.



2.1 Мал аж ахуйг эрчимжүүлэх

2.1.1. Малжуулах аяныг үргэлжлүүлэн, мал аж ахуйн үйлдвэрлэлд тогтвортой ажиллаж байгаа цөөн малтай малчин өрхийг эхний ээлжинд хамруулах арга хэмжээг авна.

2.1.2. Мах сүүний чиглэлийн ашиг шимтэй малын фермерийн аж ахуйг хөгжүүлэх сонирхолыг дэмжиж, үр ашгийг дээшлүүлнэ.

2.1.3. Сумын өвс тэжээлийн нөөцийг дотоодоосоо бүрдүүлэх, мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулна.

2.1.4. Мах экспортлох байрлалын давуу боломжоо ашиглан сум дундын стандартын шаардлага хангасан нядалгааны цехийг бий болгох асуудлыг бодлогоор дэмжинэ.

2.1.5. Сайн үүлдрийн хээлтүүлэгч нийлүүлэх, цөм сүрэг бий болгох замаар малын таваарлаг байдлыг сайжруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ..

2.1.6. Мал нядалгааны стандарт цех байгуулна.

2.1.7. Цагаан идээ, арьс шир боловсруулах, ноос ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх гэх мэт арга хэмжээг бодлогоор дэмжиж ажиллана.

2.2. Газар тариалан эрхлэлтийг нэмэгдүүлэх

2.2.1. Зармангийн говьд усалгаат газар тариалан эрхлэх, үр бордооны шинэчлэл хийх зорилт тавьж, төмс хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангаж, тэжээлийн ургамал тариалж, сумын хэрэгцээг ханган тэжээлийн бага оврын үйлдвэр байгуулна.

2.2.2. Жимс, жимсгэний тариалалтыг эрс нэмэгдүүлж, бодлогын дэмжлэг үзүүлнэ.

2.2.3. Төмс, хүнсний ногоо хадгалах зоорийг байнгын ашиглалттай болгож, сумын иргэдийг хүнсний ногоогоор хангана


2.2.4. Газар тариалангийн бүс нутагт техникийн шинэчлэл хийнэ.

2.2.5. Хүлэмжийн аж ахуй хөгжүүлэх, ялангуяа өвлийн дулаалгатай хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлнэ.

2.2.6. Тариалангийн талбайн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлнэ.

2.3. Бизнес эрхлэлтийг дэмжих

2.3.1. Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчинг бүрдүүлж, төрийн байгууллагын хуулт бус дарамт шахалтыг арилгана.



2.3.2. Брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэлийг дэмжин, стандарт эрүүл ахуйн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх боломжийг бүрдүүлж, борлуулалтын сүлжээг бий болгоно.

2.3.3. Жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг төсөл хөтөлбөрүүдэд хамруулан, ажлын үр өгөөж, хүртээмжийг дээшлүүлнэ.

2.3.4. Хувийн хөрөнгө оруулалтыг эдийн засгийн бодит салбарт оруулах нөхцөл боломжийг дэмжиж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

2.3.5. Баялаг бүтээгч иргэдийг “Алтай- Түншлэл” үзэсгэлэн худалдаанд оролцуулж, “Эрдэнэд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг сумд жил бүр зохион байгуулна.

2.3.6. Төсөл хөтөлбөрт өрх бүрийг жигд хамруулах боломжийг бүрдүүлнэ.

2.3.7. Орон нутгийн төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулна.

2.4. Ажлын байрыг нэмэгдүүлнэ

2.4.1. Ажилгүй амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдэд мэргэжил олгох сургалт зохион байгуулж, бүлэг, нөхөрлөл, хоршоололд хамруулан ажлын байртай болоход нь дэмжлэг үзүүлж ажиллана.

2.4.2. Томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажлын байр бий болгоно.

ГУРАВ. ДЭД БҮТЭЦ-ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТ

3.1. Ундны усны найдвартай эх үүсвэр.

3.1.1 Албан байгууллагууд айл өрхүүдийг цэвэр усны шугамд холбоно..

3.1.2. Ундны усны найдвартай эх үүсвэрийг үе шаттайгаар бүрдүүлж ажиллана.

3.2. Эрчим хүчний өргөтгөл, шинэчлэл.


3.2.1. Цахилгаан эрчим хүчний салбарын шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлж, шөнийн тарифт тоолуур бүрэн суурилуулна.

3.2.2. Сумын төвийн нэгдсэн халаалтын хүчин чадлыг нэмэгдүүлж айл өрхүүдийг дэвшилтэт технологи нэгдсэн халаалтанд холбох асуудлыг судалж шийдвэрлэнэ.

3.3. Зам, тээвэр, үйлдвэржилтийн бүтээн байгуулалт.

3.3.1 Арьс шир боловсруулах цехийг өргөжүүлж үйлдвэрийн хэмжээнд хүргэх

3.3.2. Сүү цагаан идээ боловсруулах үйлдвэрийг ашиглалтанд оруулж, цагаан идээний брэнд бүтээгдэхүүн бий болгоно.



3.4. Хот байгуулалт, барилга орон сууцны хөгжил.

3.4.1 ЭМТ-ийн барилын өртгөтгөл барих.

3.4.2. Нэг Сум Нэг Үйлдвэр хөдөлгөөнийг дэмжиж иргэдийн орлого ашгийг нэмэгдүүлнэ.

3.4.3. ЕБС-ын өргөтгөлийн барилга барих

3.4.4. Соёлын төвийн барилгын их засварт оруулах

3.4.5. Бизнес хөгжлийн төвийн барилгын их засварт оруулах

3.4.6. Ахмадын өргөө шинээр барих

3.5. Мэдээлэл, харилцаа холбооны дэвшил.

3.5.1. Багуудын утасны сүлжээг сайжруулах ажлыг үүрэн холбооны компаниудтай хамтран зохион байгуулна.

3.5.2. Төв суурин газрыг утасгүй интернет хэрэглэх нөхцөл боломжийг судалж, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН-АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлан зогсоож, хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

4.1 Онгон байгалиа хамгаалах.

4.1.1. Зармангийн говьд нутгийн иргэдийн оролцоотойгоор хамгаалах, үржүүлэх, талбайг нэмэгдүүлэх ажлыг төсөл хөтөлбөрт хамруулан гүйцэтгэнэ.

4.1.2. Сумын төвийн ногоон байгууламжийн усалгаа, арчилгааг бүрэн шийдвэрлэж, “НОГООН ОРЧИН” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.


4.1.3. Мод тарьсан иргэдийг урамшуулах журам гарган хэрэгжүүлж, мод үржүүлэн орлого олох боломжийг бүрдүүлнэ.

4.1.4. Уул овооны тайлга тахилгыг холбогдох ном журмын дагуу гүйцэтгэж, уул усаа тахин хайрлан хамгаалах үзлийг нийт төлөвшүүлэх ажлыг зохион байгуулна.

4.1.5. Голын ай сав, цөлжилт, элсний нүүдэл бүхий газруудыг ойжуулах иргэд, аж ахуйн нэгжийн санал санаачлагыг дэмжиж ажиллана.

4.2. Орон нутгийн тусгай хамаалалтыг нэмэгдүүлнэ.

4.2.1. Аймаг, сумын тусгай хамгаалалттай газрыг шинэчлэн баталгаажуулах, ховор амьтан ургамал, түүх соёлын газрын хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авна.



4.2.2. Байгаль орчны хуулийн дагуу иргэн бүр мэдээллэгч-хамгаалагч байх тогтолцоог бүрдүүлэн, урамшууллын систем тогтоож хэрэгжүүлнэ.

4.2.3. Ан амьтдын тооллогыг орчин үеийн багаж, тоног төхөөрөмж, арга хэрэгсэл ашиглан хийж, нөөцийн судалгааг шинэчлэн, байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөл боломжийг дээшлүүлнэ.

4.3. Цөлжилт элсний нүүдлээс хамгаалах, ногоон байгууламж.

4.3.1. Байгальд ээлтэй амьдрах ухааны хичээл сургалтыг бүх шатны боловсролын байгууллагатай хамтран хийж өсвөрийн байгаль хамгаалагчдыг удаан шингэдэг, задардаггүй хог хаягдал, сав баглаа боодлоос татгалзуулах ажлыг зохион байгуулна.

4.3.2. “Хоггүй цэвэрхэн Эрдэнэ” хөдөлгөөнийг бүх шатанд өрнүүлж, хамтдаа эрүүл цэвэр амьдрах орчныг бүрдүүлнэ.

4.3.3. Булаг шандны эхийг хамгаалан, моджуулж, ургамалжуулах ажлыг малчид, хоршоо, нөхөрлөлтэй хамтран хийж, усны ундаргыг нэмэгдүүлнэ.

4.3.4. Үерийн уснаас хөрсний эвдэрлийг хамгаалан, үерийн усыг хуримтлуулан усалгаанд ашиглах хөв, цөөрмийг 4-ээс доошгүйг улс орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр барьж байгуулна.

ТАВ. ИРГЭДИЙН ОРОЛЦОО – ЗӨВ ЗАСАГЛАЛ

5.1. Эрх мэдэлтнийг биш, эрх зүйт төрийг дээдэлнэ.

5.1.1. Төрийн албаны ажлын байранд тавигдах шаардлага бүрэн хангаж, нээлттэй шалгаруулалтанд шалгарсан хүнийг төрийн албанд томилдог зарчмыг бүрэн хэрэгжүүлнэ.


5.1.2. Төрийн албан хаагчдынг сонгуулийн үр дүнгээр намын харъяалалаар хууль бусаар халж, сольж, албн тушаал бууруулж, албан тушаал дэвшүүлж томилдог буруу зуршлыг эцэс болгоно.

5.2. Түмэндээ ойртсон төрийн үйлчилгээ

5.2.1. Тулгамдсан, нэг шаардлагатай зорилтуудыг олж тодорхойлох, тэдгээрийг шийдвэрт тусгаж хэрэгжүүлэхийн тулд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн үйл ажиллагааг тогтмолжуулж, шаардлагатай асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулдаг болно.

5.2.2. Төрийн ажил үйлчилгээг иргэдэд нээлттэй хөнгөн шуурхай, чирэгдэл, хүндрэлгүй байлгах бүх нөхцөл шаардлагыг сумын түвшинд жигд хэрэгжүүлж ажиллана.

5.2.3. Багуудын ажлын нөхцлийг сайжруулж, багийн дарга, эмч нарыг багийн төв дээр тогтмол ажиллуулах боломжийг бүрдүүлнэ.



5.2.4. Иргэдээ сонсох нээлттэй утсыг байнга ажиллуулж, санал гомдлын төрөөр бодит ажил зохиож, үр дүнг мэдэгдэж хэвшинэ.

5.3. Авилга хүнд суртал, чирэгдэлгүй зөв засаглал.

5.3.1. Төрийн байгууллагуудын хүнд сурталгүй, зарчимч, шуурхай, ил тод, нээлттэй байдлыг хангана. Үүний тулд шилэн данс, төрийн албаны бусад уахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, хүрээг өргөтгөнө.

5.3.2. Төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллага мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлдэг болно.

5.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах..

5.4.1. Малын хулгайтай тууштай тэмцэж, малын хулгайгүй сум болохыг зорино.

5.4.2. Хуулийн байгууллагын албан хаагчдын ёс зүйг сахиулж, хүний эрх, эрх чөлөөг хангана.

5.4.3. Сумын төвийг камержуулалтыг нэмэгдүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлнэ.

5.4.4. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмолжуулна.

ЭРДЭНЭ СУМЫН МАН-ЫН ХОРОО

